

ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭ

№ _____

20... оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “.....” ХХК, /регистрийн дугаар №/ түүнийг төлөөлж захирал /цаашид “Зөвшөөрөл олгогч ” гэнэ/, нөгөө талаас Улсын бүртгэлийн дугаар №:, ХХК, түүнийг төлөөлж /цаашид “Зөвшөөрөл авагч” гэнэ/ нар Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаанд Зөвшөөрөл олгогч, Зөвшөөрөл авагчийн хамтын ажиллагаа, хүч хэрэгслийг нэгтгэн зохион байгуулж хэрэгжүүлэх явдал мөн.
- 1.2. Энэ гэрээг залуусд зориулсан үйлчилгээний зах зээл дээр барааг борлуулах, үйлчилгээ явуулах ажлыг амжилттай явуулах, эдийн засгийг аль болох өндөр үр дүнд хүргэх, талуудын ажил хэрэгч хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын дор байгуулж байна.
- 1.3. Энэхүү гэрээний дагуу Зөвшөөрөл олгогч нь өөрийн бараа, ажил үйлчилгээний тэмдгийг /гэрчилгээ №/ ашиглах эрхийг Зөвшөөрөл авагчид өгөх, Зөвшөөрөл авагч нь зөвхөн гэрээнд заасны дагуу үйлчилгээний зориулалтаар ашиглана.
- 1.4. Энэхүү гэрээний дагуу Зөвшөөрөл авагч нь Зөвшөөрөл олгогчийн бараа, ажил үйлчилгээний тэмдгийг зөвхөн өөрийн үйл ажиллагаа явуулах _____ ашиглах ба бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.
- 1.5. Талууд энэхүү гэрээгээр хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, ажилтныг сургах төлөвлөгөө, гэрээний нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.6. Энэхүү Франчайзингийн гэрээг талууд харилцан тохиролцож 20... оны ... сарын ...-ны өдрөөс 20... оны ... сарын ...-ны өдөр хүртэл /.. жил, ... сар/ хугацаагаар байгуулав.

Хоёр. Талуудын харилцан тохиролцоо

2.1. Хууль тогтоомжийн талаар:

2.1.1. Зөвшөөрөл авагч, Зөвшөөрөл олгогч нь Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомж, эрх зүйн акт болон бусад эрх бүхий байгууллагаас тавьсан нөхцөл, шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.2. Хоорондын харилцааны талаар:

2.2.1. Талууд энэхүү гэрээ, бусад үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудалд шаардлага, хяналтыг тавихдаа тухайн байгууллагыг хариуцаж байгаа Захиралтай харилцана. Үүнд Зөвшөөрөл олгогч талаас “.....” ХХК-ны Гүйцэтгэх захирал, Зөвшөөрөл авагч талаас “.....” ХХК түүнийг төлөөлж захирал нар байна. Талууд шаардлагатай тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилж болох бөгөөд итгэмжлэл нь албан ёсны, бичгээр үйлдэгдсэн байна.

2.2.2. Гэрээ ёсоор талуудын ажил хэргийн харилцаа нь өдөр тутмын хамтын ажиллагаа, харилцан туслалцаа үзүүлэх явдалд үндэслэнэ.

2.2.3. Харилцан санал солилцох, үйлчилгээ үзүүлэх, үнэ тогтооход зах зээлийн шалгуур, зарчмыг баримтлана.

2.2.4. Талууд нь гэрээний хугацаанд барааны тэмдгийг гээмших, ашиглах явцдаа нөгөө талынхаа нэр хүндэд харшлах, хэвийн үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл учруулах аливаа үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх үүргийг харилцан хүлээнэ.

2.2.5. Зөвшөөрөл авагч нь үйлчилгээний маркетинг, менежментийг төлөвлөх, хөгжүүлэх ажлыг Зөвшөөрөл олгогчийн саналыг харгалзан түүнтэй ижил арга зүйгээр явуулна.

2.2.6. Талууд энэ гэрээгээр хамтран ажиллах гол зүйл болсон үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүнийг борлуулах ажлыг нэгтгэн зохицуулах, аж ахуйн үйл ажиллагаанд нэг арга зүйгээр төлөвлөх талаар бүхий л хүчин чармайлтаа дайчлан ажиллах болно.

2.3. *Өмчийн асуудлын талаар:*

2.3.1. Энэхүү франчайзингийн гэрээтэй холбоотой барааны тэмдэг нь Зөвшөөрөл олгогч өмчлөлд байна. Зөвшөөрөл авагч нь өөрийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор барааны тэмдгийг зөвхөн гэрээнд заасан зорилго, зориулалтаар ашиглана.



Гэрээний төсөл нь төлбөртэй татагдах тул бүрэн эхээр нь татахыг хүсвэл 77052494, 80802494 утсаар холбогдоно уу.